



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/189

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Тэшиг сум, Эрдэнэт хотод зохион байгуулагдсан Цанын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдын авто машины шатахууны зардалд 924,000 (есөн зуун хорин дөрвөн мянга) төгрөг, Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан Өсвөрийн бөхийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдын авто машины шатахууны зардалд 555,000 (таван зуун тавин таван мянга) төгрөг, Өвөрхангай аймгаас хивэг, эрдэст тэжээл, буудай татах шатахууны зардалд 1,054,500 (нэг сая тавин дөрвөн мянга таван зуу) төгрөг, шинэ цэцэрлэг, сургуулийн тавилга, ширээ сандал татах шатахууны зардалд 478,000 (дөрвөн зуун далан найман мянга) төгрөг, нийт 3,011,500 (гурван сая арван нэгэн мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 3,011,500 (гурван сая арван нэгэн мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН